

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

(2025 оны жилийн эцэс)

№	Хөтөлбөрт тусгагдсан үндсэн үйл ажиллагаа	Үр дүн	Шалгуур үзүүлэлт (Тухайн жилд)	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	2025 оны хэрэгжилт			Хэрэгжилтийн хувь
					Он	Түвшин	2025 он	Мэдээллийн эх сурвалж	Хүрсэн түвшин (2025)	Тайлбар	
Хүн амын бүлгүүдийн хөгжил											
1	5.1.1. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулахад гэр бүлд суурилсан үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлийн гишүүдийн бие бялдрын хөгжилд анхаарах, эрүүл, зөв амьдралын хэв маяг, эерэг хандлагыг төлөвшүүлж, гэр бүл болон нийгмийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангана.	Хүүхдийн эрүүл мэндийн байдал, бие бялдар, оюун санааг хөгжүүлэх, хамгаалах зэрэгт эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо нэмэгдэж, эрсдэлт хүчин зүйл буурна..	ЕБС, СӨББ болон бусад байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн хувь	Хувь	2024	85.0%	87.0%	ХГБХХГ-ын тайлан, мэдээ	90.0	Тайлант хугацаанд “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг сурталчлах, мөрдүүлэх чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн 121 байгууллагын эцэг эхийн зөвлөлтэй хамтран ажилласан. Үүнээс нийт 112 байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж байна. Өмнөх онтой харьцуулахад шинээр 17 байгууллага буюу 15.1 хувиар нэмэгдэж, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт 90 хувьтай байна.	100%
2	Хүүхдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүүхэд		Тоо	2024	5000	8000	ХГБХХГ-ын тайлан, мэдээ	22300	Сургуулийн өмнөх болон өсвөр үе хүүхэд залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нийт 48 төрлийн урлаг спортын уралдаан, тэмцээн болон сургалт, нөлөөллийн арга хэмжээ, өдөрлөг, чуулган зохион байгуулж давхардсан тоогоор 22300 гаруй хүүхэд хамрагдаж байна.	100%	
3	“Нэг анги-Нэг өглөө” арга хэмжээнд эцэг эх, хүүхдийн хамрагдалт		Тоо	2024	15000	15500	БТСГ-ын тайлан, мэдээ	19200	Хичээллэе-Өрнүүлбэ-Хэвшье аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн сурагчдын дунд “Нэг анги-Нэг өдөр” завсарлагааны цахим дасгалын уралдааныг 2025 оны 11 дүгээр сарын 17-ний өдрөөс 12 сарын 12-ны өдөр хүртэл зохион байгуулж, уралдаанд 22 сургуулийн 196 бүлгийн давхардсан тоогоор 19,200 сурагчдыг хамруулсан.	100%	
4	“Гэр бүлийн цогц төв” байгуулагдсан эсэх		Тоо	2024	-	-	ХГБХХГ-ын тайлан, мэдээ	-	Гэр бүлийн ордныг гэр бүлийн цогц төв болгон өөрчлөх зураг төсвийг боловсруулахад шаардлагатай төсвийг 2025 оны орон нутгийн төсөвт тусгуулж, ажлын даалгаврыг батлуулан зураг төсвийг “Үүлэн прожект” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Гэр бүлийн цогц төвийг “ аймгийн Гэр бүлийн ордныг түшиглэн байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Тайлант онд гэр бүлийн гишүүдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлийн боловсрол олгох нөлөөллийн аян, өдөрлөг,	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	

									сургалт, уулзалт зэрэг 62 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 15000 иргэн, 5000 гаруй өрх хамрагдсан байна. 2025 онд Гэр бүлийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсвөөс 3.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 38.6 сая, нийт 41.8 сая төгрөгийг зарцуулсан байна.	
5		Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт	Тоо	2024	607	807	ХГБХХГ-ын тайлан, мэдээ	936	Тайлант хугацаанд 936 хүүхдийг эрсдэлийн программд шинээр илрүүлэн бүртгэснээр аймгийн хэмжээнд нийт 3523 хүүхэд бүртгэлтэй байна. Үүнээс давхардсан тоогоор 3144 хүүхдэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн. Мөн өндөр эрсдэлтэй 297 хүүхдэд кейс нээн ажилласан байна. Гэр эргэлтийн хүрээнд 305 өрхийн 915 хүүхдэд эргэн хяналт хийж, эрсдэлийн үнэлгээг шинэчлэн 42 өрхийн 240 хүүхдийн эрсдэлийг бууруулан хамгааллын үйлчилгээ үзүүлсэн.	100%
6		Товлолын дархлаажуулалтад хамрагдалт	Хувь	2024	99.0%	99.3%	ЭМГ-ын статистик мэдээ	99.7	Тайлант хугацаанд дархлаажуулалтад хамрагдах ёстой 5,523 хүүхдээс 5,507 хүүхэд хамрагдаж, бүрэн тунгийн хамралт 99.7 хувьтай байна	100%
7		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэргийн бууралт	Тоо	2024	66	60	ХГБХХГ, ЦГ-ын статистик мэдээ	57	Тайлант хугацаанд аймгийн Цагдаагийн газар 333 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 57 буюу 17.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 276 буюу 82.9 хувь нь зөрчлийн шинжтэй байсан бөгөөд сургалт, нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулснаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад 8 хувиар буурсан үр дүнтэй байна.	100%
8		Түр хамгаалах байрны барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	2024	79%	-	ХГБХХГ, ЦГ-ын тайлан мэдээ	90%	Түр хамгаалах байрны барилгын ажлын гүйцэтгэлийг Ээлт өлгий ХХК гүйцэтгэж, 90 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2026 онд ашиглалтад хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Одоогоор үйл ажиллагаа явуулж буй "Түр хамгаалах байр"-ны урсгал зардал болон үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 40.0 сая төгрөг зарцуулсан. Тайлант онд түр хамгаалах байранд нийт 64 үйлчлүүлэгч (57 хүүхэд, 7 насанд хүрэгч) хүлээн авч, 5 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 121 удаа үзүүлж, өндөр эрсдэлтэй 15 кейсийг нээн ажилласан. "Монгол өрх" сэтгэл зүйн хүрээлэн, "Ариунсаруулбат" ТББ-тай хамтран хохирогчдыг даван туулагч болгох	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй

										зорилгоор 2 гэр бүлийн 7 хүнд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлж, даван туулагч болгосон.	
9			Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас хэвийн үзүүлэлттэй иргэдийн эзлэх жин	Хувь	2024	54.1%	55.0%	БТСГ-ын тайлан, мэдээ	55.7%	Тайлант онд хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 3-64 насны 9034 иргэдийг хамруулсан. Сорилд хамрагдсан иргэдээс 5034 иргэн буюу 55.7% нь А, В, С буюу хэвийн үнэлгээ авсан.	100%
10	5.1.2.Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудлыг тэдний онцлог, хэрэгцээнд нийцүүлж, хамтын оролцоотойгоор шийдвэрлэж, бүх төрлийн донтолт болон аливаа эрсдэлт хүчин зүйлээс сэргийлж, нөхөн сэргээх, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, нийгмийн тэгш байдлыг болгоно.	Эрэгтэйчүүдийн эрт илрүүлэгт хамрагдалт нэмэгдэж, хүйсийн дундаж наслалтын зөрүү багасаж, донтох эмгэг буурч, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн чадавх дээшилнэ	Эрэгтэйчүүдийн үзлэгт хамрагдалтын хувь	Хувь	2024	43.6%	44.7%	ЭМГ-ын статистик мэдээ	44.8%	2025 оны жилийн эцсийн байдлаар 803343 иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан бөгөөд үүнээс 359,898 эрэгтэйчүүдийг хамруулан, хамрагдалт 44.8 хувьтай байгаа нь суурь түвшнөөс 1,2 хувиар нэмэгдсэн байна.	100%
11			Хүйсийн дундаж наслалтын зөрүү	Жилээр	2023	11.62	-	ЭМГ-ын статистик мэдээ	10.78	2023 онд эрэгтэй дундаж наслалт 72.23 байсан бол 2024 онд 72.92, эмэгтэй дундаж дундаж наслалт 83.86-аас 83.7 болсон байна. Дундаж наслалтын зөрүү 11.6-аас 10.78 болж зөрүүтэй байдал буурсан.	100%
12			Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт	Хувь	2023	20.3	20.4	ХХУГ, Статистикийн хэлтсийн мэдээ	46.0	2025 оны 3 дугаар улирлын байдлаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт 46.0-д хүрч өмнөх оны мөн үеэс 12.9 функтээр өссөн	100%
13			Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэд	Хувь	2024	14.9%	15.0%	БГ, Насан туршийн суралцахуйн төвийн тайлан, мэдээ	18.2%	Аймгийн Насан туршийн суралцахуйн төв 100 гаруй төрийн байгууллага, 4 төрийн бус байгууллага, 2 олон улсын байгууллага, хувийн хэвшлийн 12 байгууллага, 10 иргэнтэй хамтарсан түншлэл, хамтын ажиллагаагаар иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд тус төвөөс 18 багц хөтөлбөрийн хүрээнд 19788 иргэнийг танхимын сургалтад хамруулсан нь нийт иргэдийн 18.02 хувийг эзэлж байна	100%
14	5.1.3.Залуучуудын сурч боловсрох, хөгжих, манлайлах санаачилгыг дэмжиж, амьдралын зөв дадал, хэв маягийг хэвшүүлж, нийгмийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлнэ.	Залуучуудын нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, эрүүл мэндийн боловсрол дээшилж, өвчлөл буурна.	Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан залуучууд	Тоо	2024	18000	20000	СУАЖЗГ-ын статистик мэдээ	28209	Залуучуудын боловсрол, хөгжлийг дэмжин 14 оюутанд 17.6 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг олгож, идэвх санаачлага гарган нийгэмд манлайлал үзүүлсэн 4 байгууллагыг шагнаж урамшуулсан. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог хангах чиглэлээр нийт 45 арга хэмжээ зохион байгуулж 28,209 залуучуудыг хамруулсан.	100%
15			Залуучуудын хөдөлмөр эрхлэлт	Хувь	2023	46.7%	46.9%	ХХУГ, Статистик мэдээлэл	50.2	15-34 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2025 оны 03 дугаар улирлын байдлаар 50.2 байгаа нь өнгөрсөн	100%

										оны мөн үетэй харьцуулахад 5.5 функтээр өссөн.	
16			Залуучуудын эрт илрүүлэгт хамрагдалт	Хувь	2024	17.4%	18.5%	ЭМГ-ын статистик мэдээлэл	34.5	Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэгт аймгийн хэмжээнд 71542 иргэн хамрагдсанаас 18–30 насны 5,874 иргэн хамрагдсан нь тухайн насны хүн амын 34.5 хувийг эзэлж байна. Оюутан залуучуудыг дэмжих сарын аяны хүрээнд 1300 залуучуудыг 5 удаагийн өдөрлөг арга хэмжээгээр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	100%
17			Нийт гэмт хэрэг үйлдсэн хүн амд залуучуудын эзлэх жин	Хувь	2024	59.4	58.0	СУАЖЗГ, ЦГ-ын статистик мэдээ	40.8	2025 онд нийт 1079 гэмт хэрэг бүртгэгдсэний 441 буюу 40.8 хувь нь 18-34 насны залуучууд байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 6.5 функтээр буурсан.	100%
18			Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин (10000 хүн амд)	Түвшин	2024	19.9	19.0	ЭМГ-ын статистик мэдээлэл	15.9	Зүрх судасны өвчлөлийн шалтгаант нас баралтын 169 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 15.9 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 16 тохиолдол буюу 1.7 промилл, хүрэх түвшнөөс 3.1 промиллээр тус тус буурсан байна.	100%
19	5.1.4.Ахмад настанд үзүүлэх эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгааллын	Ахмадууд болон анхдагчдад чиглэсэн үйл ажиллагаа өргөжиж, эрүүл мэндийн болон нийгмийн дэмжлэг тусалцаа нэмэгдэж, амьдралын чанарт ахиц гарна.	Ахмадууд болон анхдагчдад чиглэсэн олон талт арга хэмжээнд хамрагдсан ахмад	Тоо	2024	14000	14500	Ахмадын хорооны тайлан, мэдээ	18000	Ахмадын баярын өдрийг 7 өдрийн турш Орхон аймгийн 2 сум, 29 багийн 18000 гаруй ахмадууд болон багуудын залуучууд, хүүхдүүдийн төлөөлөл 5135 хүний оролцоотой “6+1” арга хэмжээг зохион байгуулсан.	100%
20	дэмжлэг тусламж, үйлчилгээг өргөжүүлж, ахмадын нийгмийн идэвх санаачилга, зөвлөн туслах үйлчилгээг дэмжин, хөдөлмөр эрхлэх хувилбарт боломжуудыг бүрдүүлж, амьдралын чанарыг сайжруулна.		Асаргаа сувилгааны цогц төв байгуулсан эсэх	Тоо	2024	-	1	ХХҮГ мэдээлэл	1	Аймгийн ИТХ-ын хурлаар батлуулсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлын жагсаалтад батлагдсаны дагуу аймгийн ХХҮГ-ын дэргэдэх Ахмадын сувиллыг “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний асаргаа сувилгааны төв” болгон өөрчлөн зохион байгуулж, “Хөвсгөл хамгаалал”ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэхээр 2025 оны 12 дугаар сард үйл ажиллагааг эхлүүлээд байна.	100%
21			Ахмад настны хөдөлмөр эрхлэлт	Хувь	2023	16.4	16.6	Статистикийн хэлтэс, ХХҮГ-ын мэдээ	13.1%	55 ба түүнээс дээш насны ахмадын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2025 оны 03 дугаар улирлын байдлаар 13.1 байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.3 функтээр өссөн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд өрхийн хөдөлмөр эрхлэн өөрсдийгөө ажлын байраар хангаж	0%

										байгаа 21 ахмад настанд нийт 197.0 сая төгрөгийн хүүгүй, барьцаагүй зээлийг 24 сарын хугацаатай олгож санхүүгийн дэмжлэгт хамруулсан. Мөн аймгийн Ахмадын хороо, Баян-Өндөр сумын ЗДТГ-аас ахмадуудад 6х20 хэмжээтэй 18 хүлэмжийг хүлээлгэн өгснөөс 9 ахмад хүлэмжийн тариалалт хийж байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 17 байгууллагын 39 ахмад настантай гэрээ байгуулан 42.1 сая төгрөгийн урамшууллыг ХЭДС-аас олгосон. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх шаардлага хангасан 7 ТББ-тай хууль эрх зүй, боловсрол, инженер техникийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ өгөхөд нь 197.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 2 ахмад настантай гэрээ байгуулан ажиллаж 3 сарын урамшуулалд 3.8 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон. Нийт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд 71 ахмад настан хамрагдсан.	
22	5.1.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие даан амьдрахад шаардлагатай хүртээмжтэй, тохируулгатай орчныг бүрдүүлж, бие махбодын болон сэтгэл зүйн сэргээн засах тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн, тэдний хөгжил, оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах боломж, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар сайжирч, нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.	Сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Тоо	2024	2101	2300	ЭМГ-ын статистик мэдээ	2466	Хөгжлийн бэрхшээлтэй 2466 иргэнийг богино хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулсан	100%
23		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт	Хувь	2023	18.2%	18.4%	ХХҮГ, Статистикийн хэлтсийн мэдээ	21.8	Аймгийн хэмжээнд 4450 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэнээс 378 хүүхэд, 1574 байнгын асаргаанд, 547 хөдөлмөр эрхэлдэг судалгаа мэдээлэл байна. Хөдөлмөр эрхлэх боломжтой 2498 хүнээс 21.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй 25 иргэн ажлын байранд зуучлагдан, 33 иргэн байнгын шинэ ажлын байранд нийт 58 иргэн ажлын байраар хангагдсан.	100%	
24		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц, барилга байгууламжийн стандартын хэрэгжилт	хувь	2024	25.0%	26.0%	ХХҮГ мэдээлэл	43.6	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан 40-45 хүний багтаамжтай, хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй зорчих боломжийг бүрдүүлсэн, шат болон тэргэнцэр орох зориулалтын буулгадаг хавтантай дунд оврын 15 ширхэг автобус нийтийн тээврийн үйлчилгээг хүргэж байна. Зам талбай, гэрлэн дохионы уулзвар, гарцад хүртээмжийн үнэлгээг Монголын	100%	

										хараагүйчүүдийн үндэсний холбооны Орхон салбартай хамтран гүйцэтгэснээр дундаж үнэлгээ 48 хувьтай үнэлэгдсэн. Мөн НҮБ-ын дэмжлэгтэйгээр ХБХЭЭХ-ноос хүртээмжийн үнэлгээг төлөөллийн 6 байгууллагад хийхэд хэрэгжилт 43.6 хувь үнэлэгдсэн.	
2.НИЙГМИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛТ											
№	Үр дүн	Салбар	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	2025 оны хэрэгжилт			Хэрэгжилтийн хувь
					Он	Түвшин	2025 он	Мэдээллийн эх сурвалж	2025 оны хүрсэн түвшин	Тайлбар	
1	Нийгмийн салбар тус бүр хүний нөөцийг удирдан чиглүүлэх бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлсэн баян.	Боловсрол	Бодлогын баримт бичгийн хэргэжилт	Хувь	2024	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	БГ	Бодлогын баримт бичгийг боловсруулсан.	Боловсролын салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг 5 зорилт 14 арга хэмжээтэйгээр боловсруулж 2026 оноос хэрэгжилтийг хангахаар төлөвлөсөн.	100%
2		Эрүүл мэнд			2024	89.5%	90%	ЭМГ	90.6%	2025 онд нийт эрүүл мэндийн салбарт 2069 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 452 их эмч, 507 сувилагч ажиллаж байна. -Орхон аймгийн Эрүүл мэндийн салбарын 2025-2030 оны хүний нөөцийн төлөвлөлтийг 2 арга хэмжээ 8 шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилт 90,6 %-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,7%-иар нэмэгдсэн байна.	100%
3		Соёл			2024	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	СУАЖЗГ	Бодлогын баримт бичгийг боловсруулсан.	Соёлын салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулж 2026 оноос хэрэгжилтийг хангахаар төлөвлөсөн.	100%
4		Спорт			2024	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	БТСГ	Аймгийн биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийг 2026-2028 онд хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан.	Аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй биеийн тамир, спортын 45 холбоодоос хүний нөөцийн судалгаа авч, спортын 9 төрөлд дасгалжуулагчийг шинээр бэлтгэж ажиллуулах, мэргэшсэн ажилтан, албан хаагчдыг 10-аар нэмэгдүүлэх, спортын 3 төрөлд 45 дасгалжуулагч, шүүгчдийг давтан сургаж мэргэшүүлэхээр төлөвлөөд байна.	100%
5		Хөдөлмөр, нийгмийн хамгаалал			2024	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	ХХҮГ, НДГ, ХГБХХГ	Бодлогын баримт бичгийг боловсруулж байна.	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын байгууллагууд болох ХХҮГ, ГБХХХГ, НДГ-ууд нь хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулж 2026 оноос хэрэгжилтийг хангахаар төлөвлөсөн.	0%
6	Нийгмийн салбарын хүний нөөцийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ	Нийгмийн салбарын байгууллагууд	Хүний нөөцийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг тодорхойлох судалгаа хийсэн	Тоо	2024	-	7	Салбарын байгууллагуудын тайлан мэдээ	7	Тайлант хугацаанд салбарын байгууллагууд хүний нөөцийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг тодорхойлох судалгааг хийсэн байна.	100%

	тодорхойлогдож, чадварлаг албан хаагчдаар хүний нөөцийн бүрдүүлэлт хийгдсэн байна.		байгууллага								
7		Боловсрол	Хүний нөөцийн бүрдүүлэлт	Хувь	2024	92%	94%	Боловсролын газрын статистик мэдээ	98	2025-2026 оны хичээлийн жил эхлэхэд ерөнхий боловсролын сургуулиудын 92 сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлагдаж 78 ажлын байр шийдвэрлэгдсэн бөгөөд үлдсэн 14 сул орон тоонд тэтгэвэрт гарсан багш болон цагийн багш нарыг ажиллуулж дутагдлыг нөхсөн.	100%
8		Эрүүл мэнд		Хувь	2024	80.1%	83%	ЭМГ-ын статистик мэдээ	92,7%	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүний нөөцийн хангалт 91.4 хувьтай байна. Мөн сум, өрхийн эрүүл мэндийн 9 төвд нийт 181 ажилтан ажиллаж байгаагаас 50 нь эмч, 50 нь эмнэлгийн мэргэжилтэн байна. Эдгээр төвүүдийн хүний нөөцийн хангалт, хүртээмж 94.1 хувьтай байгаа нь орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна.	100%
9		Соёл		Тоо	2024	6	-	СУАЖЗГ-ын тайлан мэдээ	0	Орон нутагт дутагдалтай байгаа хормейстер, концертмейстер, балетмейстер найруулагч мэргэжлээр суралцахад орон нутгаас дэмжлэг үзүүлэх талаар салбарын байгууллагууд болон албан хаагчдад мэдээлэл хүргэж ажилласан. Тайлант онд дээрх мэргэжлээр суралцах хүсэлт гаргасан албан хаагч байхгүй байсан тул хормейстер, концертмейстер, балетмейстер, найруулагч мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, цаашид орон нутагтаа ажиллуулах зорилгоор СУИС-тай хамтран ажиллахаар төлөвлөж байна. Мөн "Уран эгшиг" сургуулийн төгсөх ангийн сурагчдад дээрх чиглэлээр суралцсан тохиолдолд төлбөрийн дэмжлэг үзүүлэх талаар мэдээлэл өгч, 1 сурагчийн ар гэрийнхэнтэй уулзаж, санал солилцсон.	0%
10		Спорт		Хувь	2024	68%	-	БТСГ-ын тайлан мэдээ	78%	Тайлант онд зэрэглэлтэй дасгалжуулагч бэлтгэх сургалтыг 2 удаа, шүүгч бэлтгэх сургалтыг аймагтаа 2 удаа зохион байгуулж, 71 биеийн тамир багш, дасгалжуулагч нар эрх авсанаар салбарын хүний нөөцийн хангалтыг 78%-д хүргэсэн. Үүнд: -Сагсан бөмбөгийн В зэрэглэлийн дасгалжуулагчийн эрхийг 1 дасгалжуулагч, С зэрэглэлд 10 дасгалжуулагч, -Хөл бөмбөгийн D зэрэглэлийн эрхийг 20 биеийн тамирын багш, -Сагсан бөмбөгийн шүүгч бэлтгэх анхан шатны сургалтад 30 биеийн тамирын багш;	100%

										<p>-Волейболын анхан шатны шүүгчийн сургалтад 9 багш дасгалжуулагч тус тус хамрагдаж эрхээ авсан.Мөн шинээр спортын 2 төрөлд улсын шүүгчийн эрх авсан.</p> <p>Зэрэглэлтэй дасгалжуулагч бэлтгэснээр:</p> <p>-Сагсан бөмбөгийн С зэрэглэлийн дасгалжуулагч нь өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд багаа оролцуулах эрхтэй</p> <p>-Сагсан бөмбөгийн В зэрэглэлийн дасгалжуулагч нь сагсан бөмбөгийн Дээд лигийн тоглолтод баг дасгалжуулж оролцуулах эрхтэй.</p> <p>-Хөл бөмбөгийн D зэрэглэлийн дасгалжуулагч нь орон нутагт баг хичээллүүлэх эрхтэй.</p> <p>-Шүүгчийн /сагсан бөмбөг, волейбол/ анхан шатны сургалтад хамрагдсанаар аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг шүүх эрхтэй болсон.</p>	
11		Хөдөлмөр, халамж үйлчилгээ		Тоо	2024	2	-	ХХҮГ-ын тайлан мэдээ	-	Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд хэрэгжилтийг 2026 оноос тооцохоор тусгасан.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
1 2		Нийгмийн даатгал		Тоо	2024	6	-	НДГ-ын тайлан мэдээ	-	Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд хэрэгжилтийг 2026 оноос тооцохоор тусгасан.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
1 3		Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгаалал		Тоо	2024	9	3	ХГБХГ-ын тайлан мэдээ	27	Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газарт ажлын байранд шилжүүлэн ажиллах журмын дагуу 3 албан хаагч шилжин ажиллаж, шинээр 24 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажилд авч, тэдний нийгмийн баталгааг бүрэн хангаж ажиллалаа.	100%
1 4	Нийгмийн салбарын албан хаагчдын ажлын бүтээмж, гүйцэтгэл дээшилж, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байна.	Боловсрол	Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	2024	ЕБС-76.3% СӨББ-90.4%	ЕБС-76.5% СӨББ-90.6%	Гүйцэтгэлийн үнэлгээний дүн	ЕБС-77.57% СӨББ-94.88%	ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд төрийн өмчийн 17 сургуулийн 968 багш хамрагдаж, үнэлгээний дүн 77.57%, өмнөх оны үнэлгээнээс 1.15%-аар ахисан, хүүхдийн 31 цэцэрлэгийн 322 бүлгийн багш хамрагдаж үнэлгээний дүн 94.68%, өмнөх оны үнэлгээнээс 4.78%-аар ахисан байна	100%
1 5			9-р ангийн сурагчдын унших чадвар, математикийн	Хувь	2024	Унших чадвар 41.1%	Унших чадвар 52.0%	Үнэлгээний үр дүн	Унших чадвар 54.08% Математик 30.9%	БЯ, БҮТ, БЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу багшийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтад 9 дүгээр ангийн сурагчдын монгол хэл, математикийн хичээлээр	50.0%

			хичээлийн гүйцэтгэл			Математик 33.7%	Математик 35.0%			бичгийн шалгалт өгсөн сурагчдын гүйцэтгэлийн үр дүнгээр тооцсон. Монгол хэлний хичээлийн бичгийн шалгалтын үр дүнг авч үзэхэд 2024 онд 49%, 2025 онд 54.08% буюу 5.08%-өөр ахисан, харин математикийн хичээлийн бичгийн шалгалтын үр дүнг авч үзэхэд 2024 онд 32.4%, 2025 онд 30.9% буюу 1.5 хувиар буурсан байна.	
1 6			Цэцэрлэгийн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний гүйцэтгэл	Хувь	2024	-70.2%	71.0%	Үнэлгээний үр дүн	-	2025 оны 09 дүгээр сарын 01-нээс СӨБ-ын сургалтын шинэчилсэн хөтөлбөр хэрэгжиж хэлсэнтэй холбогдуулан Боловсролын яамнаас цэцэрлэгийн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг хичээлийн жилийн эхэнд биш СӨБ төгссөний эцсийн үнэлгээ болгож хичээлийн жилийн төгсгөлд буюу жил бүрийн 05 дугаар сард хийхээр шийдвэрлэж үнэлгээ хийх хугацаанд өөрчлөлт оруулсан. Үүнтэй холбоотойгоор 2025 онд СӨБ дүүргэсэн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 2025 онд хийгдээгүй. 2026 онд СӨБ дүүргэсэн хүүхдүүдийн үнэлгээ 2026 оны 05 дугаар сард хийгдэнэ.	0%
1 7			Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	2024	ЕБС-75.8% СӨББ-87.8%	ЕБС-76.0% СӨББ-88.0%	Гүйцэтгэлийн үнэлгээний дүн	ЕБС-80.91% СӨББ-92.29%	БШУ-ны сайдын 2023 оны А/115 дугаар тушаалаар Сургалтын байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээг 4.5 сард БҮТ-тэй хамтран зохион байгуулсан. Хүүхдийн цэцэрлэгийн 31 байгууллага гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдаж аймгийн дундаж 92.29 хувь буюу өмнөх хичээлийн жилийн үнэлгээнээс 4.29 хувиар ахисан, ерөнхий боловсролын сургуулийн 17 байгууллага гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдаж аймгийн дундаж 80.91 хувь буюу өмнөх хичээлийн жилээс 4.91 хувиар ахисан байна.	100%
1 8		Эрүүл мэнд	Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилт	Хувь	2022	83.9 %	85%	ЭМГ-ын тайлан мэдээ	95,2%	Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт 95.2 хувьтай буюу “Үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн байна.	100%
1 9		Соёл	Соёл, урлагийн үйлчилгээ үзүүлсэн иргэдийн нийт хүн амд эзлэх жин	хувь	2024	30%	-	СУАЖЗГ-ын тайлан мэдээ	304086	Аймгийн Хүүхэд залуучуудын театр 2025 онд 57052 иргэнд үзвэрээр үйлчилсэн нь нийт хүн амын 54%-ийг эзэлж байна.	100%
2			Соёлын	хувь	2024	94%	95.5%	СУАЖЗГ-ын	95.0%	Соёл урлагийн байгууллагуудын 2025 оны	66.7%

0			байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж					тайлан мэдээ		жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн дундаж 95.0 %-тай хэрэгжсэн.	
2 1			Соёлын салбарын албан хаагчдын мэргэжил, ур чадварын үнэлгээний дундаж	Хувь	2024	-	-	СУАЖЗГ-ын тайлан мэдээ	16.0%	Соёл урлагийн салбарын 9 байгууллагад 127 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 120 албан хаагчийн ур чадварыг үнэлж, ур чадварын нэмэгдлийг олгосон. Соёл урлагийн салбарын албан хаагчдын ур чадварын дундаж үнэлгээ 16.0%	100%
2 2		Спорт	Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилт	Хувь	2024	87%	90%	БТСГ-ын тайлан мэдээ	94,6%	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдаас Орхон аймгийн Засаг даргатай соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын төрийн чиг үүргийг 2025 онд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээнд спортын чиглэлээр 13 арга хэмжээг хэрэгжүүлж, гэрээний хэрэгжилт 94,6 хувиар дүгнэгдсэн.	100%
2 3		Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилт	Хувь	2024	90.6%	91%	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын тайлан мэдээ	94.2%	2025 онд аймгийн Засаг даргаас ГБХНХ-ын сайдтай хамтран ажиллах гэрээний хэрэгжилт 94.2 хувьтай хэрэгжиж улсын хэмжээнд салбартаа 2 дугаар байранд орсон байна.	94.2%
2 4	Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамж дээшилж, ажлын байранд сэтгэл зүйн таатай орчин бүрдсэн байна.	Нийгмийн салбарын байгууллагууд	Албан хаагчдын сэтгэл ханамж	Хувь	2024	-	Судалгаа хийж суурь түвшинг тодорхойлох	НДГ	Судалгаа хийж суурь түвшинг тодорхойлсон	Нийгмийн салбарын албан хаагчдаас “Сэтгэл зүйн дархлааны түвшин”, “Сэтгэл ханамжийн судалгаа” гэсэн 2 төрлийн судалгааг авсан. Сэтгэл зүйн дархлааны судалгаанд салбарын 4700 албан хаагчаас 1788 албан хаагчид бүрэн хамрагдсан. Судалгаанд нийт албан хаагчдын 38.0% хамрагдаж, байгууллагын стрессийн суурь түвшин тодорхойлогдсон. Салбарын албан хаагчдын сэтгэл зүйн дархлаанд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс нь ажлын байрны стрессээс гадна, аливаа ажлыг гүйцэтгэхэд бусдын нөлөөлөл орж ирдэг болох нь, залуу албан хаагчдын хувьд ажлын шаардлага үүсэхэд бусдаас тусламж хүсэж чадахгүй байгаа нь, тийм нөхцөл боломжоор хангагдаагүй байгаа нь, өөрийн хувийн ур чадварыг хөгжүүлэхэд цаг гаргаж чадахгүй байгаа нь сэтгэл зүйн дархлаанд сөргөөр нөлөөлж байгаа бол байгууллагын стрессийн түвшинг нэмэгдүүлдэг хүчин зүйлсэд ажлын ачаалал, урамшууллын шударга бус байдал, хамт олны харилцаа, уур амьсгал зэрэг нь нөлөөлж байгааг судалгааны үр дүнгээс харж болохоор байна.	100%

										<p>Нийгмийн салбарын албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаанд 520 хүн буюу нийт албан хаагчдын 11.0 хувийг хамруулсан. Судалгаанд хамрагдагчдын 87.5% эмэгтэй албан хаагчид 12.5% эрэгтэй албан хаагчид байна. Насны хувьд 34% нь 31-40 насны ид хөдөлмөрийн насны албан хаагчид байгаа бол 32,7% нь 41-50 насны албан хаагчид 17.5% нь 51-с дээш насны ахмад албан хаагчид байна. Судалгааны үр дүнгээс харахад:</p> <ul style="list-style-type: none"> •Ажлын орчин, хамт олны уур амьсгал, удирдлагын харилцаатай холбоотой үзүүлэлтүүдэд сэтгэл ханамж харьцангуй өндөр; •Харин цалин, урамшуулал, орлогын тогтвортой байдалтай холбоотой үзүүлэлтүүдэд сэтгэл ханамж сул байна. Энэ нь байгууллагын дотоод зохион байгуулалт тодорхой хэмжээнд тогтвортой боловч материаллаг урамшууллын бодлогыг сайжруулах шаардлагатай байгааг илтгэж байна. 	
2 5	Нийгмийн салбарын байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байна.	Нийгмийн салбарын байгууллагууд	Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байгууллага	Тоо	2024	6	3	БГ, ЭМГ	ӨЭТМ-5 Сургууль-1 Цэцэрлэг-1	<p>Тайлант хугацаанд ерөнхий боловсролын 3 дугаар сургууль болон “Одод” цэцэрлэгт ISO чанарын стандартыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд энэ ажлын хүрээнд 2 удаагийн сургалтыг байгууллагын багш, ажилтнуудад зохион байгуулж, хүний нөөцийг бэлтгэх мэргэшүүлэх сургалтад дээрх 2 байгууллагаас тус бүр 2 ажилтныг хамруулж бэлтгэл ажлыг үе шаттайгаар хангаж байна. Мөн Эрүүл мэндийн газраас 2025 онд олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг 5 ӨЭМТ, БОЭТ-д нэвтрүүлэхээр зөвлөх үйлчилгээнд 20.0 сая төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр “World standart conculting” компанитай гэрээ байгуулан өрхийн эрүүл мэндийн 5 төв шинээр амжилттай нэвтрүүлснээр анхан шатны 8 эрүүл мэндийн байгууллагууд ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог 100% нэвтрүүлсэн байна.</p>	100%
Дундаж үнэлгээ										89.1%	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР